



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Судалгааны удирдах зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны ажлыг зохион байгуулахтай холбогдуулан ТУШААХ НЬ:

1. ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааг 2013 онд багтаан зохион байгуулж, үр дүнг Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулахыг удирдах зөвлөлийн дарга (Д. Мөнхбат)-д даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд (Ж. Амарсанаа)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 380 дугаар тушаал, 2010 оны 246 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.


САЙД  Н. УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 сарын 21-ний өдрийн 188 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

- Дарга Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Орлогч дарга Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
- Нарийн бичгийн дарга БХЗГ-ын БЗДХ/ДОХ/сүрьеэгийн хяналт, урьдчилан сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга /зөвшилцсөнөөр/
- БТГ-ын анагаах ухааны хөгжил, шинэтгэлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- ЭХЭМҮТ-ийн захирал
- ЦССҮТ-ийн захирал
- ХӨСҮТ-ийн халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал
- ХӨСҮТ-ийн Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны албаны эрдэмтэн нарийн бичгийн дарга
- ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны дарга
- ЭМХТ-ийн Статистик мэдээллийн албаны дарга
- Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч



Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн

НЭМГ-ын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

ДЭМБ-ын ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

НҮБ-ын Хүүхдийн сангийн ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

НҮБ-ын Хүн амын сангийн ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Төгс бүсгүйчүүд ТББ-ын гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

Хамтдаа ТББ-ын гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

Залуус эрүүл мэнд ТББ-ын гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

Дэмжих төв ТББ-ын гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

22

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 сарын
21-ний өдрийн 188 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

**ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгааны
удирдах зөвлөлийн үйл ажиллагааны удирдамж**

Нэг. Нийтлэг үндэслэл


- 1.1 ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтын тандалт судалгаа (цаашид “судалгаа” гэх)-ны удирдах зөвлөл (цаашид “удирдах зөвлөл” гэх) нь судалгааг зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, судалгаанд оролцогч байгууллагуудын ажлын уялдааг хангах, хяналт, үнэлгээг нэгтгэн зохицуулах чиг үүрэгтэй ажиллана.
- 1.2 Удирдах зөвлөл нь ажлын үр дүнгээ ЭМЯ-ны Удирдлагын зөвлөл, Эрүүл мэндийн сайдын зөвлөлд тайлагнана.

Хоёр. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Судалгааг мэргэжил, аргазүйн нэгдсэн удирдлагаар хангах
- 2.2 Хэрэгжилтийн явцад хяналт тавих
- 2.3 Судалгааны үзүүлэлт, аргачлал, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн, батлах, аргазүйн дэмжлэг үзүүлэх

Гурав. Удирдах зөвлөлийн хурал

- 3.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн ердийн олонх оролцсоноор удирдах зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болно
- 3.2 Удирдах зөвлөл нь улирал тутам хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр ээлжит бус хурал хуралдуулж болно
- 3.3 Асуудлыг хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ
- 3.4 Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулж, хурал болохоос 7 хоногийн өмнө гишүүдэд тараана



- 3.5 Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэл хөтөлж, удирдах зөвлөлийн даргаар баталгаажуулж, хурлаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна
- 3.6 Удирдах зөвлөлийн хурлаас шаардлагатай гэж үзсэн асуудлаар бусад яам, байгууллагаас саналыг бичгээр авч, зөвлөмжид тусгаж болно
- 3.7 Удирдах зөвлөлийн даргын эзгүйд хурлыг орлогч дарга хуралдуулна

Дөрөв. Удирдах зөвлөлийн гишүүдийн эрх үүрэг

- 4.1 Удирдах зөвлөлийн гишүүн тодорхой асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх санал оруулах эрхтэй бөгөөд ингэхдээ удирдах зөвлөлийн даргатай урьдчилан тохиролцсон байна. Хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг санал оруулж байгаа гишүүн хариуцан хангуулна
- 4.2 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар гишүүн санал гаргах эрхтэй бөгөөд гаргасан саналыг тухайн гишүүний төлөөлж буй байгууллагын санал гэж үзэх тул уг асуудлаар өөрийн байгууллагын удирдлагатай урьдчилан тохиролцсон байна
- 4.3 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, зөвлөмжийг гишүүд өөрийн төлөөлж буй байгууллагын удирдлагуудад танилцуулах үүрэг хүлээнэ
- 4.4 Гишүүн удирдах зөвлөлийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд удирдах зөвлөлийн даргад мэдэгдэж, хэлэлцэх асуудлын талаар саналаа бичгээр ирүүлнэ.